

## Төв банк юу хийж чадахгүй вэ?

*Шинэ Зеландын төв банкны ерөнхийлөгч асан Доналд Брашийн 2001 онд хэлж байсан үгнээс*

Иргэд, олон нийтийн зүгээс төв банк хэтэрхий их зүйл чадна гэж хүлээх нь нэлээд түгээмэл. Төв банкны үүрэг ролийг ийнхүү хэтрүүлж ойлгох явдал Америкт сүүлийн жилүүдэд их байна. Тухайлбал, 90-ээд оны дундаас бий болсон эдийн засгийн тогтвортой өсөлт нь Америкийн төв банкны мөнгөний бодлоготой нягт холбоотой гэж ойлгож байна. Энэ нь мэдээж төв банк оновчтой бодлого явуулсантай холбоотой. Гэхдээ эдийн засгийн өсөлтийн гол хөдөлгөх хүч нь компьютерийн үйлдвэрлэл гэх мэт нийт эдийн засагт бүтээмжийн өсөлтийг бий болгосон технологийн дэвшлүүд байв. Мөнгөний бодлого тэдгээр дэвшлүүдийг бий болгоогүй юм.

Яг л үүн шиг Шинэ Зеландад ч, магадгүй Австралид ч төв банк, мөнгөний бодлогын эдийн засагт үзүүлэх нөлөөг нь дэгсдүүлэх явдал бий. Гэхдээ бодит байдал дээр инфляцийг тогтвортой байлгалаа гээд төв банкууд үйлдвэрлэл эсвэл ажил эрхлэлтийн өсөлтийн трендийг огцом өөрчилж чадахгүй. Үүнтэй харьцуулахад засгийн газрууд бол аль алинд нь шууд нөлөөлөх боломжтой.

Энд би хэдийгээр үйлдвэрлэлийн өсөлтийг юу тодорхойлдогийг тогтоохыг зориогүй ч, энэ талаарх судалгаануудад ихэвчлэн мөнгөний бодлоготой бараг холбоогүй зүйлс байдгийг онцлох нь зүйтэй.

Жишээ нь, зарим судалгаанууд өндөр татвар нь хүмүүсийн ажиллах, хуримтлуулах, шинийг эрэлхийлэх инсентивээр дамжаад эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлдгийг харуулдаг. Харин зарим судалгаанууд хувийн өмчийг хамгаалах нь динамик өсөлтийг бий болгодог ч гэж үздэг. Хүний нөөц, боловсрол нь эдийн засгийн өсөлтийг тодорхойлогч болдог гэсэн үр дүнгүүд ч бий. Эдгээрээс гадна эдийн засгийн өсөлтийг тодорхойлогч олон хүчин зүйл байх бөгөөд зах зээл дээрх сигналыг бүдгэрүүлж, хөрөнгө оруулалтын хуваарилалтыг оновчгүй болгох төрийн зохицуулалтууд ч үүнд хамаарна. Эдгээр хүчин зүйлсийг зөв зүгт нь чиглүүлэх бодлогоор эдийн засгийн өсөлтийг бий болгодог ч, яг үнэндээ тэр дунд төв банкны нөлөөлж чадах зүйл ховор юм.

Тэгвэл ажилгүйдлийн хувьд? Богино хугацаанд бол мөнгөний бодлогоор ажил эрхлэлтэд ч, үйлдвэрлэлд ч нөлөөлөх боломжтой. Гэхдээ урт хугацаанд үргэлжлэх нөлөөллийг би харж байгаагүй.

Тэгвэл ажил эрхлэлтэд тууштай нөлөө үзүүлэх зүйл нь юу байж болох вэ? Энэхүү асуултын хариулт нь төв банк гэхээсээ засгийн газар болон тухайн нийгэмтэй бүхэлд нь холбоотой байдаг...Ажлын байр бий болох асуудал нь эцсийн эцэст хөдөлмөрийн зах зээлтэй холбоотой хууль тогтоомж, ажилгүйдлийн тэтгэмж, боловсролын тогтолцооны асуудал юм. Эдгээр зүйлс нь мөнгөний бодлоготой бараг хамаагүй. Харин засгийн газрын бодлого болон иргэдийн хүсэл эрмэлзэл, хандлагаас шалтгаална. Тэгээхэр үйлдвэрлэлийн өсөлт, ажилгүйдлийн түвшин нь үндсэндээ тухайн нийгмийн соёл, иргэдийн хандлагатай холбоотой зүйл гэж би хардаг.

Бид өнөөдрийн хэрэглээг маргаашийнхтай харьцуулахад алийг нь илүүд үзэж байна вэ? Бид мэдлэг боловсролыг хэр чухалчилдаг вэ? Бид улсаас хамааралтай байхыг хүсдэг үү, хараат бус байхыг хүсдэг үү? Бид хувийн өмчийн эрхийг хэр эрхэмлэдэг вэ? Эдгээр асуултуудын хариулт нь

эдийн засгийн өсөлтийн ч тэр, ажил эрхлэлтийн ч тэр гол тодорхойлогч нь бөгөөд мөнгөний бодлоготой бараг л хамаагүй зүйлс билээ.

Төв банкууд инфляцийг нам тогтвортой байлгаснаараа бодит үйлдвэрлэл, потенциал үйлдвэрлэлийн зөрүүг аль болох бага байлгахыг зорьдог. Гэхдээ энэ нь эдийн засгийн хэт халалт эсвэл уналтыг бүрэн арилгах баталгаа гэсэн үг биш юм.

Жишээ нь, потенциал үйлдвэрлэлийн чиг хандлага нь гарт мэдрэгдэгдэж, нүдэнд харагдаж эсвэл хэмжигддэг зүйл биш. Ийм ч учрас ямар ч төв банкны хувьд үйлдвэрлэл нь потенциал хэмжээнээсээ их, бага эсвэл тэнцүү байгааг мэдэх боломжгүй. Мэдээж ажиллах хүчний тоо, бүтээмжийг ойролцоогоор төсөөлөөд ирээдүйн үйлдвэрлэлийн талаар тойм тооцооллуудыг хийж болно. Гэхдээ амьдрал дээр ажиллах хүчний тоо шилжилт хөдөлгөөнөөс болоод өөрчлөгддөг. Бүтээмж ч таамаглахын аргагүй өөрчлөгддөг гэдгийг АНУ-ын сүүлийн 40 жилийн түүх харуулсан.

Түүнчлэн мөнгөний бодлого нь эрэлтээр дамжуулан инфляцид нөлөөлөх явцад цаг хугацааны хоцрогдол үүсдэг бөгөөд энэхүү хоцрогдол нь нэг улсын хувьд ч аль цаг хугацаа вэ гэдгээс хамаараад харилцан адилгүй. Төв банк мөнгөний бодлогоо өөрчлөх, тэрхүү өөрчлөлт нь бодит эдийн засагт нөлөөлж улмаар үнийн түвшнийг өөрчлөх хооронд эдийн засагт урьдчилж таамаглахын аргагүй олон өөрчлөлтүүд бий болдог. Тухайлбал, дэлхийн эдийн засаг өөрчлөгдөх, цаг агаар гэнэт хувирч ган болох, засгийн газар татварын эсвэл цагаачлалын бодлогоо өөрчлөх гэх мэт зүйлс тохиолдож болно. Эдгээр шокууд нь эрэлт нийлүүлэлтийн харьцаанд нөлөө үзүүлснээр бодит болон потенциал үйлдвэрлэлийн зөрүүд нөлөөлдөг. Иймд ямар ч боловсронгуй төв банк байлаа гээд бодит үйлдвэрлэлийн өсөлтийг потенциал хэмжээнд нь барих боломжгүй гэдгийг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй.

Тэгэхээр зарим үед эдийн засаг удаашрах, эсвэл бүр агших үед ч төв банкныг шууд буруутгах нь тохиромжгүй. Эдийн засагт учирч буй шокуудыг хамгийн бага байлгахын тулд засгийн газрууд алгуур бөгөөд таамаглахуйц хэлбэрээр төсвийн бодлого хэрэгжүүлвэл мөнгөний бодлогод том дэм болно. Түүнчлэн засгийн газрууд хөдөлмөрийн зах зээлийг аль болохоор уян хатан байлгаснаар эдийн засагт шок үүсэх үед ажилгүйдэл тогтмол өсөхгүй байх нөхцөлийг ч бүрдүүлэх боломжтой.

Эцэст нь, төв банкууд бүсийн эсвэл аль нэг салбарын асуудлыг шийдэх боломжгүй гэдгийг санах нь зүйтэй. 90-ээд оны дундуур Шинэ Зеландад нэлээд хүчтэй инфляцийн дарамт үүсч, мөнгөний бодлогыг чангаруулах шаардлага бий болоод байв. Олон нийтийн үзэл бодлоор бол энэхүү инфляцийн дарамт нь Аукландад үүсээд байсан үл хөдлөх хөрөнгийн хөөсрөлтэй холбоотой байв. Иймд зөвхөн Аукланд дахь нөхцөл байдлаас болж яагаад Шинэ Зеланд даяар хүүг өсгөх ёстой юм бэ гэдэг асуултуудтай тулгарч байв.

Энэ үед би нэг л хариулт өгч байсан. Шинэ Зеландын бүх хэсэгт нэг л мөнгөн тэмдэгт үйлчилдэг нэг холбоо учир төв банк өөр бүс нутгууддаа өөр хүү тогтоох, өөр ханш тогтоох боломжгүй. Өнөөдөр ч энэ зарчим хэвээр.

Тухайн үед Шинэ Зеландын доллар урт хугацааны тэнцвэрт түвшнээсээ доогуур ханштай байна гэж ихэнх ажиглагчид үзэж байв. Иймд экспортын сектор харьцангуй зөөлөн мөнгөний бодлогын үр өгөөжийг хүртэж байлаа.

Харин барилга гэх мэт дотоодын зах зээлд үйлчилдэг салбаруудын хувьд нөхцөл байдал нэлээд хүнд байсан бөгөөд, энэ нь сүүлийн 1-2 жилд гадагш чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөн их байсантай холбоотой байв. Гэтэл мөнгөний бодлогоор барилга эсвэл өөр аль нэг секторын асуудлыг шийдэх нь бараг боломжгүй. Мөнгөний бодлого нь нийт эдийн засагтаа инфляцийг хяналттай байлгахад л чиглэхээс, аль нэг салбарт чиглэх аргагүй юм.

Иймд төв банкууд хэдийгээр эдийн засагтаа чухал хувь нэмэр оруулдаг ч урт хугацаанд авч үзвэл эдийн засгийг хурдтай өсгөх, ажилгүйдлийг багасгах эсвэл аль нэг салбарыг дэмжиж чадахгүй.